

## УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**ХЯТАДААС ЭНЭТХЭГ—ХЯТАДЫН ХОЙГТ  
ЯВУУЛЖ БАЙГАА БОДЛОГО****Ч. Сувд**

БНХАУ-аас Зүүн Өмнөд Азийн бүс нутагт явуулж буй гадаад бодлогод Энэтхэг-Хятадын хойг онцгой байр эзэлдэг юм. БНХАУ-тай шууд хил залгаж, Энэтхэгийн болоод Номхон далайн уулзвар дээр оршдог эдийн засаг, цэрэг—улс төрийн стратегийн чухал ач холбогдол бүхий энэ бүс нутгийг Бээжин эрт дээр цагаас эхлэн ихээхэн сонирхож иржээ. Харин Хятадын удирдагчдын үзэж байгаагаар Зүүн Өмнөд Ази газарзүйн байршил, байгаль, эдийн засгийн нөөц баялагаараа ч Хятадад ойр дөт ашигтай юм. Эдийн засаг, соёл болон бусад олон талаар уламжлалт харилцаа холбоотой явж ирсэн, мөн дээрх орнуудад эрт дээр үеэс хятад гаралтай иргэд—хуацяо нар нүүдэллэн суурьшиж, улмаар өөрсдийн нөлөө бүхий нийгэмлэг, холбоо гэх зэрэг байгууллагуудтай болж, тухайн улс орны улс төр, нийгэм—эдийн засгийн амьдралд нөлөө бүхий хүч болсон зэрэг хүчин зүйлүүд нь энэ бүс нутагт Бээжингийн бодлогыг хэрэгжүүлэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Түүхийн хуудсыг сөхөн үзвээс Хятад бүр 2000 жилийн тэртээгээс Вьетнам, Бирм, Индонези зэрэг Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн улсуудыг халдан довтлох бай болж байсан байна. Түүгээр ч үл барам бүр «манай тооллын өмнөх I зуунд Хятад Зүүн Өмнөд Азид өөрийн жанжлалаа тогтоож тэр цагаас хойш энэ районыг өөрийн нөлөөний бүс гэж үзэж иржээ»<sup>1</sup> Хятад улс өөрөө өрнөдийн империалист гүрнүүдийн хагас колонийн эрхшээлд орсон XIX зуунд Зүүн Өмнөд Азийн улсуудад учруулж байсан Хятадын эзэн хаадын аюул занал түр зогссон билээ. Орос оронд Октябрийн социалист их хувьсгал ялж, түүний дүнд дэлхийн ууган социалист орон ЗХУ бий болж өсөж бэхжсэн, дэлхийн II дайнд гитлерийн фашизм, Японы милитаризмыг ЗХУ тэргүүтэй энхийг эрхэмлэгч хүчин ялсан, дэлхийн социалист систем бүрэлдэн тогтсон, улс түмний үндсээ чөлөөлөх хөдөлгөөн эрчимтэй өрнөх болсон зэрэг олон гайхамшигтай үйл явдал дэлхий ертөнцийн төрх байдлыг хувьсган өөрчилсөн юм. Ийм нөхцөл байдалд Вьетнамын ард түмэн дэлхийн социализмын орнуудын улс төр, цэрэг—эдийн засгийн тусламжтайгаар Америкийн империализмын түрэмгийллийг таслан зогсоож, ялалт байгуулсан билээ.

Тийнхүү Америкийн империализм ялагдал хүлээж, эхлээд Вьетнамаас дараа нь Энэтхэг—Хятадын хойгийн бусад нутгаас гарч явсны дараа Хятадын эрх баригчид Кампучи дахь Пол Потын дэглэмийг

1. Новости Вьетнам. № 10, 1984.

Энэтхэг-Хятадын хойгийн улс түмний эсрэг өөрийн булаан эзлэх жанжлах бодлогыг хэрэгжүүлэх зэвсэг болгож ашиглах болов.

1975-1978 онуудад Пол Потын дэглэм Бээжингийн шууд заалт, заавар, тусламжтайгаар Вьетнамтай хилийн будлиан үүсгэн өдөөн хатгалга хийж Вьетнамын өвгөд, хөгшид, хүүхэд, эмэгтэйчүүдийн амь насыг бүрэлгэж, орон сууц, байшин барилгыг галдан шатаах үйл ажиллагааг явуулж байв. 1977 оны эцсээр Пол Потын дэглэм БНСВУ-тай дипломат харилцаагаа тасалж, Вьетнамын эсрэг зэвсэгт халдлагад шууд бэлтгэж эхэлсэн юм.

1979 онд Энэтхэг-Хятадын хойгийн улс түмэн өөрсдийн Нэгдмэл үйл ажиллагаагаар энэ бүс нутагт жанжлалаа тогтоох гэсэн Бээжингийн санаархалд шийдвэртэй няцаалт өгсний үр дүнд Кампучи улс тусгаар тогтнолоо сэргээж, Лаос улс дэвшил хөгжлийн замд орсон билээ. Энэ үйл явдал Энэтхэг-Хятадын хойгийн гурван улсын ах дүүгийн найрамдал, нэгдэл нягтралыг бэхжүүлэх, энэ бүс нутагт энх тайван тогтвортой байдлыг хангахад чухал алхам болсон юм. Гэвч Энэтхэг-Хятадын хойгт Бээжингийн жанжлах бодлогын анхны үйл ажиллагаа нь 1979 онд Вьетнамын эсрэг үйдсэн зэвсэгт түрэмгийлэл юм. Хятад эрх баригчид Вьетнам дахь хуацяо нарыг бөөн бөөнөөр нь Вьетнамаас гаргах ажилыг зориуд зохион байгуулж үүнийхээ шалтаг болгон БНСВУ нь Хятад гаралтай иргэдийг хавчин гадуурхаж, мөрдөж байгаа мэтээр Вьетнамын эсрэг суртал ухуулга гүтгэлгийн өргөн кампани дэгдээсэн юм.

1979 оны 2-р сард Хятадаас Вьетнамын эсрэг явуулсан түрэмгийллийн дараа Бээжингийн болон өрнөдийн суртал нэвтрүүлэг «Кампучийн асуудал»<sup>2</sup> гэгчийг дэлхий нийтэд шуугиулж эхлэв. Хятадын албан ёсны суртал нэвтрүүлэг ч БНСВУ-ыг «бага жанжлал» тогтоох зорилгоор Кампучийн эсрэг «түрэмгийлэл» хийж энэ бүс нутагт булаан эзлэх бодлого хэрэгжүүлж, АСЕАН-ы улсуудын аюулгүй байдалд занал учруулж буй «зөвлөлтийн их жанжлалын дуулгавартай зарц» гэх зэргээр харааж зүхэх болов.

Вьетнамын эсрэг хэрэгжүүлсэн Бээжингийн бас нэг арга хэмжээ нь 1976-1980 онд Вьетнамд үзүүлэх эдийн засгийн бүх хэлбэрийн тусламжтаар зогсоож, мэргэжилтнээ татсан явдал юм.

1982 оны 6-р сард бас «Ардчилсан Кампучийн эвслийн Засгийн газар» гэгчийг Бээжингийн шууд санаачилга, оролцоотойгоор байгуулав. Энэхүү «эвслийн Засгийн газар» гэгч үнэн хэрэгтээ Хятадаас Энэтхэг-Хятадын хойгт жанжлах бодлогын бас нэг илрэл юм.

1983 оны 12-р сард БНХАУ-ын засгийн газрын урилгаар «Ардчилсан Кампучийн эвслийн Засгийн газар» гэгч тоглоомын засгийн газрын толгойлогч Нородом Сианук, Сон Сан нар Бээжинд «зочлон» ирэв. ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан, ХКН-ын Зөвлөхүүдийн Төв комиссын дарга Дэн Сяопин нар тэднийг «хүндэтгэж» хүлээн авч уулзахдаа: «Хунтайж Сианукаар удирдуулсан эвслийн засгийн газрыг Хятад улс эрс шийдвэртэй дэмжиж байна», «Та нар тэмцлийн фронтын тэргүүн шугам дээр зогсож байна... Бид урьдын адил та нарын шударга эмцэлд дэмжлэг үзүүлнэ»<sup>3</sup> гэж мэдэгджээ. Энэ нь Энэтхэг—Хятадын хойгийн болон АСЕАН-ы орнуудын хооронд яриа хэлэлцээ хийх хандлагад саад хийх, улмаар энэ бүс нутагт жанжлан ноёрхох гэсэн Бээжингийн санаархлын бас нэг тод илрэл мөн.

2. «Patriot» February 20. 1979.

3. «Жэньминь жибао», 1983. ХП. 25

Хятадын удирдлага энэтхэг—Хятадын хойгийн гурван орны эсрэг явуулж буй булаан эзлэх түрэмгий бодлогодоо АСЕАН-ы гишүүн улсуудыг татан оруулах төлөвлөгөөг эртнээс хэрэгжүүлж байгаа билээ. 1978 онд Дэн Сяопин (Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч байхдаа) Тайланд, Сингалур, Малайзидээ «айлчилсан» нь үүний нотолгоо мөн.

Энэ айлчлалын явцад Хятадын удирдлага «Кампучий асуудал», «Вьетнамын түрэмгийлэл» гэгчийн талаар АСЕАН-ы орнуудыг өөрийнхөө бодлогод татан оруулах, тухайлбал Америкийн засаг захиргаатай зохицох замаар АСЕАН-ы гишүүн орнуудыг БНКАУ-ын эсрэг өдөөн хатгах буюу хорлон сүйтгэх үйл ажиллагаандаа ашиглах, Пол Пот—Иенг Сарийн бүлгийн үйл ажиллагааг дэмжиж, Тайландаар дамжуулан энэ бүлэгт цэрэг—эдийн засгийн тусламж үзүүлэх асуудлыг ярилцжээ. 1978 оны 4-р сард Хятадын Гадаад явдлын Яамны сайд агсан Хуан Хуа Вьетнамын эсрэг «БНХАУ-АСЕАН-ы нэгдсэн фронт» байгуулах санал тавьж байв<sup>4</sup>

Ер нь АСЕАН-ы орнуудыг ЗХУ, БНСВУ-ын эсрэг бодлогынхоо хүрээнд татан оруулах санаархалаа хэрэгжүүлэх үүднээс АСЕАН-тай эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхээ Хятад амалсаар байгаа юм.

Хятадын удирдлага Энэтхэг—Хятадын хойгийн гурван улсын эсрэг явуулах түрэмгий бодлогоороо Вьетнамын дайнд ялагдах хүлээсэн Америкийн «Зүүн Өмнөд Азид эргэн ирэх» гэсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ямар нэг хэмжээгээр тус дөхөм үзүүлж байгаа юм. Хятад—Америкийн стратегийн сонирхол энд зарим талаараа нийцэж байна. Хятад, Америкийн аль аль нь Вьетнам Лаос, Кампучийн хувьсгалт хүчнээс хөндийрүүлэх, Вьетнам болон АСЕАН-ы орнуудыг бие биеий нь өөдөөс мөргөлдүүлэх, тухайлбал Тайланд болон АСЕАН-ы гишүүн орнуудыг Энэтхэг—Хятадын хойгийн гурван улсын эсрэг хандуулж, Ази болон дэлхий дахинд «Зөвлөлтийн болоод Вьетнамын аюул занал» гэгчийг өргөн сурталчилахад онцгой анхаарч, ажил явууллагаа зохицуулж байгаа билээ.

«ЗХУ-Вьетнамын жанжлалын» эсрэг нэгдсэн фронт байгуулах саналын хүрээнд Хятад АСЕАН-тай, тухайлбал Индонез, Сингапуртай харилцаагаа хэвийн болгох үйл явцыг түргэтгэх, Тайландыг Вьетнам, БНАЛАУ, БНКАУ-ын эсрэг өдөөн хатгах ажил явууллагын талбар болгон ашиглах, Тайланд-Кампучийн хилийн бүсэд хурцадмал байдал бий болгоход Тайландын нутгийг ашиглаж байгаа юм. Мөн Бээжин АСЕАН-ы улсуудын эдийн засгийн холбоог цэрэг-улс төрийн түрэмгий эвсэл холбоо болгох, Америк-Японы төлөвлөгөөг хөхүүлэн дэмжих, энэ зорилгоор Япон-Америкийн «Аюулгүйн гэрээ»-г цаашид улам бэхжүүлэх, Номхон далайд Америкийн усан флотын хүчин чадлыг нэмэгдүүлэхийг сайшааж байна.

1981 оны зун Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жао Зыян Малайз, Сингапур, Тайландад айлчлав. Жао Зыян дээрх орнуудын удирдагчидтай хийсэн хэлэлцээнийхээ явцад Вьетнам, Лаос, Кампучийн эсрэг үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэг асуудал гол байр суурь эзэлжээ.

Хятадын эрх баригчид кампучийн ард түмнийг төлөөлж чадахгүй «Кампучийн эвслийн засгийн газар» гэгчийг хүлээн зөвшөөрүүлэх оролдлогыг улайран хийж байна. Бээжингийн шахалт, АСЕАН-ы орнуудын саналаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXIV чуулганаас эхлээд түүнээс хойших удаа дараагийн чуулганаар «Кампучийн асуудал» гэгчийг авч хэлэлцэж байгаа юм.

4. «Жэньминь жибао», 1978. IX. 19.

1984 оны эхээр Хятадын төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жао Зыян АНУ-д хийсэн айлчлалынхаа үеэр кампучийн байдлын талаар мэдээлэл хийж «Хятад улс Вьетнамыг эсэргүүцсэн капучийн эх оронч хүчнийхний тэмцэл, Н. Сианук тэргүүтэй Ардчилсан кампучийн эвслийн засгийн газрыг эрс шийдвэртэй дэмжиж байна»<sup>5</sup> гэжээ.

Энэ нь Хятадын удирдлага «Ардчилсан кампучийн эвслийн засгийн газар» гэгчийг Америк болон өрнөдийн бусад хөрөнгөтөн орнуудаар өргөн дэмжүүлэх, «Кампучийн асуудал» гэгчид Америкийн засаг захиргааг идэвхтэй татан оруулах гэсэн санаархал юм. Вашингтон ч Бээжингийн санаа бодлыг ойлгож байгаагаа илэрхийлэн Хятадын удирдлагаас Вьетнам болон Зүүн Өмнөд Азийн талаар баримталж буй бодлогыг дэмжиж байгаагаа мэдэгдсэн билээ.

БНКАУ-тай хил залгаа Тайландын нутагт бүгж буй кампучийн хувьсгалын эсэргүүчүүд Кампучийн эсрэг байгаа зэвсэгт халдлага, өдөөн хатгалга хийж, сургууль, эмнэлэг, тариалангийн талбайг галдан шатаах, энгийн номхон иргэдийг тонон дээрэмдэх, алж талах үйл ажиллагааг явуулсаар байна. Энэ бүгдийг Хятад, Америк, Тайланд болон өрнөдийн гүрнүүд «кампучийг чөлөөлөх ард түмний тэмцэл» мэтээр дүрслэн харуулахыг оролдож, энэ чиглэлд өөрсдийн улс төр, суртал нэвтрүүлгийн бүх хэрэглийн зохицуулан уялдуулж, бүрэн ашиглаж байна. Тайландын нутгаас Америкийн зэр зэвсгээр зэвсэглэсэн цэргийн нисэх онгоц, тэнгисийн хөлөг онгоц кампучийн агаарын болон усан хилийг байнга зөрчиж байна.

1985 оны 1-р сард Бээжин «Ардчилсан кампучийн эвслийн засгийн газар» гэгчийн тэргүүн Нородом Сианукийг Бээжинд их шуугиантай хүлээн авч кампучийн ард түмний «чөлөөлөх тэмцэл»-тэй Хятад улс эв санааны нэгдэлтэй байгаагаа дахин илэрхийлэв.<sup>6</sup> Энэ нь үнэн хэрэгтээ кампучийн хувьсгалын эсэргүү хүчний үйл ажиллагааг цаашид улам идэвхжүүлэн зохицуулах, улс төр, цэрэг—эдийн засгийн тусламж өгөх замаар БНКАУ, БНСВУ-ын эсрэг Бээжингийн бодлогыг эрчимжүүлэх Зүүн Өмнөд Азийн энэ бүс нутгийн байдлыг нэлэнхүйд нь хурцатгахад чиглэж байна. Өөр нэг жишээг дурьдахад 1985 оны 1-р сарын эхээр Кампучи—Тайландын хил дээр болсон зэвсэгт тулалдаан юм. Энэ үеэр Хятадын цэрэг Вьетнамын нутагт цөмрөн орж, хэд хэдэн өндөрлөгийг булаан эзлэж, Вьетнамын хил орчмын Хатуен, Хоангльншон, Лайтяу зэрэг мужийн хүн амын эсрэг хэд хэдэн удаа зэвсэгт ажиллагаа үйлджээ.<sup>7</sup> Вьетнамын нутагт шургалсан Хятадын хорлон сүйтгэх бүлгүүд тагнуул хийж замуудыг минижүүлж, Вьетнамын хүн амын дотор дайсагнасан суртал нэвтрүүлэг явуулж байв.

Энэтхэг—Хятадын хойгт Бээжингийн явуулж буй бодлогын үндэс нь БНКАУ-ын удирдагчдын их гүрний үндсэрхэх дээрэнгүй үзлийн ойлголтоос шууд үүдэн гарч буй Азийн болон олон улсын бодлогод Хятадын үүрэг роль, эзлэх байр суурьтай шууд холбоотой юм. Хэдийгээр Хятадын удирдагчид «Хятад хэзээ ч их гүрэн болохгүй» гэж аман дээрээ нэг биш удаа мэдэгдэж байгаа боловч сүүлийн хэдэн арван жилийн туршид хөрш зэргэлдээ орнуудынхаа талаар явуулж ирсэн тэдний бодлогоос үзэхэд Бээжин Азийн янз бүрийн хэсэгт өөрийн нөлөөний бүс нутагтай болохыг санаархаж байна. Гэвч бодит нөхцөл байдлаас болоод Хятадын эрх баригчдын дээрх зорилт бүрэн хэрэг-

5. «Жэньминь жибао», 1984. IV. 23.

6. «Жэньминь жибао», 1985. I. 5.

7. «Үнэн», 1985. 1. 29.

-жиг чадахгүй байгаа бөгөөд Вьетнам, Лаос, кампучийн ард түмний баатарлаг тэмцлийн замнал нь ах дүү гурван орны эсрэг гадаадын аливаа зэвсэгт түрэмгийлэл ямар ч ажилтанд хүрч байгаагүй түүхтэй билээ.

## ПОЛИТИКА КИТАЯ В ОТНОШЕНИИ СТРАН ИНДОКИТАЙСКОГО ПОЛУОСТРОВА

(Резюме)

Этот важный в экономическом военно-стратегическом отношении район издавна привлекал внимание Китая занимает особое место его внешней политике. Более того, Китай рассматривает его как зону распространения своего влияния. Первым шагом в реализации гегемонистской политики Китая явилась открытая агрессия во Вьетнаме.

После поражения американского империализма во Вьетнаме, китайские руководители начали использовать режим Пол Пота в Кампучии в качестве орудия своей реакционной политики по отношению к народам Индокитая.

Созданное в июне 1982 г. при активном участии Китая так называемое «Объединенное правительство Демократической Кампучии» на самом деле служило гегемонистской политике Китая в отношении трех стран Индокитая. Китайское руководство пытается привлечь участие в осуществлении своих агрессивных планов страны АСЕАН. Об этом свидетельствуют визиты Дэн Сяопина в Тайланд, Сингапур, Дю Малайзию и его переговоры с руководителями этих стран. Пекин поддерживает в определенной мере американскую политику «возвращения в Юго-Восточную Азию». Это свидетельствует о том, что интересы США и Китая зачастую совпадают. Они раздували миф о «Вьетнамской угрозе», преследующий цель дискредитировать СРВ в глазах мировой общественности.

Во время своих визитов в Малайзию, Сингапур, Тайланд в 1981 г. премьер госсовета Жао Зыян уделял особое внимание антивьетнамской, антилаосской антикампучийской сторонам деятельности руководства этих стран. Провокационные вылазки Тайланда против Кампучии прицениваются китайско-американскими средствами массовой информации как «справедливая народная борьба за освобождение Кампучии».

Во время визита Нородома Сианука в Пекин в январе 1985 г. китайская сторона выразила полную солидарность с так называемой «освободительной борьбой кампучийского народа».

Политика Пекина в отношении стран Индокитая вытекает и тесно связана великоханьских шовинистических устремлений китайского руководства с его позициями на международной арене.

Однако справедливая борьба народов Индокитая лишает возможности осуществляться этим коварным замыслом китайского руководства.